



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨААТҮГ-ЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/16/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор Ч.Дашдаваа
Утас: 260512 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Бизкон Аудит" ХХК
Утас: 99119107 Цахим хаяг: info@bizcon.mn

Улаанбаатар хот
2021 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.ТҮВШИНДЭМБЭРЭЛ ТАНАА

2021.03.15 № 07/915
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

ТӨБЗГ-аас баталсан 2020 оны зорилтот түвшингээр Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ нь нийт 32 бүлэг уран бүтээл бүтээхээр төлөвлөжээ. Үүнээс гүйцэтгэлээр 2020 онд нийт 22 бүлэг кино уран бүтээл бүтээсэн байна. Тухайлбал: Засгийн газрын тогтоолоор гүйцэтгэдэг "Түүхийн хүрд" баримтат киног 12 бүлгээс 12 бүлгийг, баримтат кино 10 бүлэг бүтээхээс тайлант онд Ц.Намсрайн 100 жил баримтат кино 10 бүлгийг бүтээжээ. Харин 10 бүлэг уран сайхны кино бүтээх зорилт Ковид-19 цар тахлын нөлөөгөөр биелэгдээгүй байна. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг 68.8 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	187,181,104.62	46,563,462.51
1.1.2	Дансны авлага	31,135,419.07	33,034,780.39
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	770,151.08	734.36
1.1.4	Бусад авлага	550,000.0	0.00
1.1.6	Бараа материал	525,947,744.75	517,346,573.64
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	745,584,419.52	596,945,550.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,184,887,707.04	3,059,158,020.53
1.2.2	Биет бус хөрөнгө	768,978,372.80	770,178,372.81
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,953,866,079.84	3,829,336,393.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,699,450,499.36	4,426,281,944.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	198,000.00	10,382,520.00
2.1.1.3	Татварын өр	12,714,362.40	1,277,133.24
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	500,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,912,362.40	12,159,653.24
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,912,362.40	12,159,653.24
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	124,660,692.93	145,352,055.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878,331,806.60	3,878,331,806.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	683,545,637.43	390,438,428.47
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,686,538,136.96	4,414,122,291.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,699,450,499.36	4,426,281,944.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	466,394,462.81	178,085,548.93
2	Борлуулалтын өртөг	46,445,925.82	15,068,160.76
3	Нийт ашиг(алдагдал)	419,948,536.99	163,017,388.17
4	Түрээсийн орлого	205,393,372.73	160,857,954.48
5	Хүүний орлого	5,218,192.75	1,411,064.77
6	Бусад орлого	36,414,903.64	1,279,363.62
7	Борлуулалт, маркетингийн зардал		
8	Ерөнхий ба удирдлагын зардал	528,953,024.20	506,153,591.74
9	Бусад зардал	14,688,418.61	1,322,936.63
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	9,913.46	12,691.91
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(57,142,464.71)
12	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	123,343,476.76	(238,040,530.13)
13	Орлогын татварын зардал	12,334,347.67	141,106.48
14	Татварын дараах ашиг (алдагдал)	111,009,129.09	(238,181,636.61)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	111,009,129.09	(238,181,636.61)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	572,628,145.00	4,575,620,644.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	111,009,129.09	111,009,129.09
Зарласан ногдол ашиг	-	-	(91,636.66)	(91,636.66)
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	683,545,637.43	4,686,538,136.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(4.84)	(4.84)
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	683,545,632.59	4,686,538,132.12
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(238,181,636.61)	(238,181,636.61)
Өмчид гарсан өөрчлөлт	20,691,363.00	-	(38,275,567.51)	(17,584,204.51)
Зарласан ногдол ашиг	-	-	(16,650,000.00)	(16,650,000.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.60	390,438,428.47	4,414,122,291.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	780,205,129.84	369,191,283.18
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	774,986,937.09	363,007,122.18
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	2,276,861.00
	Бусад мөнгөн орлого	5,218,192.75	3,907,300.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	739,805,380.14	492,137,181.97
	Ажиллагчдад төлсөн	129,456,630.60	132,398,537.53
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,500,000.00	38,459,659.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	284,990,074.55	93,721,131.50
	Ашиглалтын зардалд төлсөн	175,635,194.83	109,220,984.26
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	13,174,377.00
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	141,106.48
	Татварын байгууллагад төлсөн	95,325,615.89	51,360,230.20
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	117,612.00
	Бусад мөнгөн зарлага	13,897,864.27	53,543,544.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,399,749.70	(122,945,898.79)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	2,411,064.77
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	1,000,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	1,411,064.77
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,821,104.55	3,745,500.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,146,104.55	681,500.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	1,650,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	3,675,000.00	1,414,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(33,821,104.55)	(1,334,435.23)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	300,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	300,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	91,636.66	16,650,000.00
	Төлсөн ногдол ашиг	91,636.66	16,650,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(91,636.66)	(16,350,000.00)
4	Валютын ханшийн зөрүү	9,913.46	12,691.91
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,496,921.95	(140,617,642.11)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	180,684,182.67	187,181,104.62
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,181,104.62	46,563,462.51

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Хувь	Зөрүү
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Кино уран бүтээл	бүлэг	32	32	22	68.8	(10)
	Түүхийн хүрд	бүлэг	12	12	12	100	-
	Баримтат кино	бүлэг	10	10	10	100	-
	Уран сайхны кино	бүлэг	10	10	-	-	(10)
2	Нийт орлого	мян.төг	713,420.9	470,000.0	341,633.9	72.7	(128,366.1)
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	713,421.0	470,000.0	341,633.9	72.7	(128,366.1)
	Улсын төсвөөр гүйцэтгэсэн ажил	мян.төг	414,400.0	110,000.0	45,100.0	41.0	(64,900.0)
3	Нийт зардал	мян.төг	590,087.4	467,144.8	579,687.2	124.1	112,542.4
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	112,769.9	105,000.0	104,508.9	99.5	(491.1)
4	Нийт ашиг	мян.төг	123,333.5	2,855.2	(238,040.5)	(8,337.2)	(240,895.7)
5	Цэвэр ашиг	мян.төг	111,009.2	2,569.6	(238,181.6)	(9,269.0)	(240,751.2)
6	Төсвийн төлбөрт	мян.төг	185,229.3	125,289.3	173,174.9	138.2	47,885.6
	НӨАТ-д	мян.төг	44,582.7	30,800.0	27,823.5	90.3	(2,976.5)
	НДШ-д	мян.төг	40,500.0	46,728.0	38,723.9	82.9	(8,004.1)
	ААНОАТ-т	мян.төг	-	785.5	12,004.7	1,528.3	11,219.2
	ХХОАТ-т	мян.төг	35,678.4	18,370.0	18,036.6	98.2	(333.4)
	Бусад төлбөр хураамж	мян.төг	64,468.2	24,424.0	59,936.2	245.4	35,512.2
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	91.6	4,181.8	16,650.0	100.0	12,468.2
8	Хөрөнгө оруулалт, их засвар	мян.төг	30,221.7	100,514.7	71,808.7	71.4	(28,706.0)
9	Нийт авлага	мян.төг	32,455.5	36,000.0	33,035.5	91.8	(2,964.5)
10	Нийт өглөг	мян.төг	12,714.3	2,000.0	12,159.7	608.0	10,159.7
11	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	0.8	1.0	1.53	153.9	0.5
12	Ажиллагсдын тоо	хүн	21	22	19	86.4	(3)
13	Цалингийн сан	мян.төг	172,942.9	179,835.6	165,059.4	91.8	(14,776.2)
14	Дундаж цалин	мян.төг	686.3	681.2	723.9	106.3	42.7

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын захирал О.Түвшиндэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд он удаан жил болсон, төлөгдөх эсэх нь тодорхойгүй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 30-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд "Бизкон Аудит" ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар, "Бизкон Аудит" ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 21/12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ гэсэн статустай байна. Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын өмчийг ТӨБЗГ 100.0 хувь эзэмшиж байна.

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Баримтат болон уран сайхны кино бүтээх;
- Кино хальс боловсруулах;
- Хөгжим, дуу чимээ гүйцэтгэх түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Оюуны өмчийн тухай
- Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай
- Хувь хүний орлогын албан татварын тухай зэрэг хуулиуд байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 590,0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 273,1 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	187.2	46.6	(140.6)
Дансны авлага	31.1	33.0	1.9
Татвар, НДШ-ийн авлага	0.8	0.0	(0.8)
Бусад авлага	0.6	-	
Бараа материал	525.9	517.3	(8.6)
Үндсэн хөрөнгө	3,184.9	3,059.2	(125.7)
Биет бус хөрөнгө	769.0	770.2	1.2
Нийт хөрөнгийн дүн	4,699.5	4,426.3	(273.2)
Богино хугацаат өр төлбөр	12.9	12.2	(0.7)
Өмч-төрийн	124.7	145.4	20.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878.3	3,878.3	0.0
Хуримтлагдсан ашиг	683.6	390.4	(293.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,699.5	4,426.3	(273.2)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, дансны авлага, татвар, НДШ-ийн авлага, бусад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, дансны өглөг, татварын өр, бусад богино хугацаат өр төлбөр, эздийн өмч, хуримтлагдсан дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 46.6 сая төгрөг болж 140.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд борлуулалтын орлого эрс буурснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 33.0 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр өссөн нь харилцагч байгууллагуудаас авах авлагын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он дамнасан, тайлант хугацаанд ямар нэгэн өөрчлөлт ороогүй төлөгдөх эсэх нь тодорхойгүй, 2006-2019 онуудад үүссэн 28.2 сая төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 517.3 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр буурсан нь дуусаагүй үйлдвэрлэл 23.8 сая төгрөгөөр, ТӨБЗГ-ын 2020 оны 03 сарын 10-ны өдрийн 74 тоот тогтоолоор балансаас балансад 20.6 сая төгрөгийн кино хальс шилжиж ирсэн, мөн 0,2 сая төгрөгийн аккумулятор цэнэглэгч худалдан авснаар өсч, 15.0 сая төгрөгийн "Түүхийн хүрд" баримтат киног Үндэсний төв архивт хүлээлгэн өгсөн, Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын захирлын 2020 оны 07 сарын 10-ны 17/07 тоот тушаалаар 1978 оноос хойш бүртгэгдэж, олон жил хадгалагдаж, биет хөрөнгийн шинж чанараа алдсан, технологийн хоцрогдолд орсон, олон жил эргэлтэд орж элэгдэж муудсан, цаашид ашиглах нь эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон 28.2 сая төгрөгийн киноны сэлбэг, 3.2 сая төгрөгийн аж ахуйн материал, 6.7 сая төгрөгийн хувцас хэрэглэл зэрэг нийт 38.2 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 24.0 сая төгрөг, ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас балансад 20.6 сая төгрөгийн кино хальс үнэ төлбөргүй хүлээн авсан, нийт 44.6 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд байсан ашиглагдах боломжгүй болсон киноны сэлбэг, аж ахуйн материал, хувцас хэрэглэл зэрэг байна.

Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн зүйлгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,059.2 сая төгрөг болж 125.7 сая төгрөгөөр буурсан нь барилга байгууламжийн капитал засвараар 69.7 сая төгрөг, худалдан авалтаар 0.6 сая төгрөгөөр өссөн, ТӨБЗГ-ын 2020 оны 04 сарын 30-ний өдрийн А-1/764 дугаартай зөвшөөрлөөр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон нийт 155.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 11.0 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, 115.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 22.8 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 2.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, ТӨБЗГ-ын 2020 оны 07 сарын 06-ны өдрийн 394 дугаар тогтоолоор 61.1 сая төгрөгийн барилга байгууламжийг данснаас хассан, нийт 138.9 сая төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь барилга байгууламжид капитал засвар хийснээр 69.7 сая төгрөгөөр, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 0.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2020 оны 04 сарын 30-ны өдрийн А-1/764 дугаартай албан бичгийн дагуу 148.9 сая төгрөгийн хөрөнгийг, ТӨБЗГ-ын 2020 оны 07 сарын 06-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор 61.1 сая төгрөгийн барилга байгууламж, 2.8 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 770.1 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь Смарт ложик ХХК-ийн "Smart balance pro" санхүүгийн программ хангамжийг 1.5 сая төгрөгөөр худалдан авч, тайлант хугацаанд 0.3 сая төгрөгийн хорогдол тооцоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12.2 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-т төлөх түрээсийн өглөг 10.1 сая төгрөг, ажиллагсад төлөх бусад богино хугацаат өр төлбөр 0.5 сая төгрөгөөр өссөн, татварын өр төлбөр 11.4 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-т урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 145.4 сая төгрөг болж 20.7 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2020 оны 03 сарын 10-ны 74 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 211.4 сая төгрөгийн балансын үнэ, 190.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 111 ширхэг хөрөнгийг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-т балансаас балансад шилжүүлсүгэй” гэсэн үндэслэлээр нэмэгдүүлж бүртгэснээс шалтгаалсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэлд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна

Хуримтлагдсан ашиг 390.4 сая төгрөг болж 293.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүн болох 238.2 сая төгрөгийн алдагдал, Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын захирлын 2020 оны 07 сарын 10-ны 17/07 тоот тушаалаар акталсан бараа материалын үлдэгдэл өртөг 38.3 сая төгрөг, ТӨБЗГ-т шилжүүлсэн ногдол ашиг болох 16.7 сая төгрөг зэргээс шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2019 оны 12 сарын 16-ны 542 дугаар тогтоолоор Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 470.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 467.1 сая төгрөгөөр, нийт ашгийг 2.9 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 2.6 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалт, их засварын арга хэмжээнд 80.9 сая төгрөгийг, камерын хөл 1 ширхэгийг 9.2 сая төгрөгөөр, кино гэрэлтүүлэг 3 ширхэгийг 7.0 сая төгрөгөөр, зөөврийн компьютер 1 ширхэгийг 3.4 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалгүй 2.6 сая төгрөгийн цэвэр ашигтайгаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 341.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 579.7 сая төгрөгийн зардал гарган, 238.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь Соёл урлагийн газраас баримтат киноны санхүүжилт 45.1 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 296.5 сая төгрөг зэргээс бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Хувь	Зөрүү
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Кино уран бүтээл	бүлэг	32	32	22	68.8	(10)
	Түүхийн хүрд	бүлэг	12	12	12	100	-
	Баримтат кино	бүлэг	10	10	10	100	-
	Уран сайхны кино	бүлэг	10	10	-	-	(10)
2	Нийт орлого	мян.төг	713,420.9	470,000.0	341,633.9	72.7	(128,366.1)
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	713,421.0	470,000.0	341,633.9	72.7	(128,366.1)

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	Улсын төсвөөр гүйцэтгэсэн ажил	мян.төг	414,400.0	110,000.0	45,100.0	41.0	(64,900.0)
3	Нийт зардал	мян.төг	590,087.4	467,144.8	579,687.2	124.1	112,542.4
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	112,769.9	105,000.0	104,508.9	99.5	(491.1)
4	Нийт ашиг	мян.төг	123,333.5	2,855.2	(238,040.5)	(8,337.2)	(240,895.7)
5	Цэвэр ашиг	мян.төг	111,009.2	2,569.6	(238,181.6)	(9,269.0)	(240,751.2)
6	Төсвийн төлбөрт	мян.төг	185,229.3	125,289.3	173,174.9	138.2	47,885.6
	НӨАТ-д	мян.төг	44,582.7	30,800.0	27,823.5	90.3	(2,976.5)
	НДШ-д	мян.төг	40,500.0	46,728.0	38,723.9	82.9	(8,004.1)
	ААНОАТ-т	мян.төг	-	785.5	12,004.7	1,528.3	11,219.2
	ХХОАТ-т	мян.төг	35,678.4	18,370.0	18,036.6	98.2	(333.4)
	Бусад төлбөр хураамж	мян.төг	64,468.2	24,424.0	59,936.2	245.4	35,512.2
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	91.6	4,181.8	16,650.0	100.0	12,468.2
8	Хөрөнгө оруулалт, их засвар	мян.төг	30,221.7	100,514.7	71,808.7	71.4	(28,706.0)
9	Нийт авлага	мян.төг	32,455.5	36,000.0	33,035.5	91.8	(2,964.5)
10	Нийт өглөг	мян.төг	12,714.3	2,000.0	12,159.7	608.0	10,159.7
11	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	0.8	1.0	1.53	153.9	0.5
12	Ажиллагсдын тоо	хүн	21	22	19	86.4	(3)
13	Цалингийн сан	мян.төг	172,942.9	179,835.6	165,059.4	91.8	(14,776.2)
14	Дундаж цалин	мян.төг	686.3	681.2	723.9	106.3	42.7

Нийт орлогын гүйцэтгэл 341.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 128.4 сая төгрөг буюу 27.3 хувиар тасарсан нь тайлант онд Ковид-19 цар тахал дэгдсэнээс үйл ажиллагаа тасалдсан шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 579.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 112.5 сая төгрөг буюу 24.1 хувиар хэтрүүлсэн. Энэ нь Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулахдаа ТӨБЗГ-т төлөх түрээсийн төвлөрүүлэлт, мөн тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны 04 сарын 30-ний өдрийн А-1/764 дугаартай зөвшөөрлөөр үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарз зэргийг тооцож тусгаагүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн их засвар, 2 нэр төрлийн худалдан авах ажилд өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 71.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 238.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 240.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үйл ажиллагааны орлого 27.3 хувиар дутуу биелсэн, зардал 24.1 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТӨБЗГ-ын 2020 оны 05 сарын 28-ны 315 тоот тогтоолын дагуу тайлант онд 16.7 сая төгрөгийн ногдол ашиг буюу 2019 оны цэвэр ашгийн 15 хувийг төвлөрүүлэхээс 16.7 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна. Мөн 57.6 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээс 44.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ нь статусаараа Төлөөлөн удирдах зөвлөлгүй, ТӨБЗГ-аас томилогдсон ажлын хэсэг тус ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, түүний биелэлтийг дүгнэж, тус газрын хурлын тогтоолоор чиглэл өгдөг байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 53.6 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Хувь
Албан шаардлага	1	0	1	0	0	100
Зөвлөмж	3	3.8	2	3.8	1	66,7
Нийт дүн	4	3.8	3	3.8	1	83.3

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 157.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 50.8 сая төгрөгийн алдааг залруулж, шилэн дансны 53.6 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, төлөгдөх эсэх нь тодорхойгүй 28.2 сая төгрөгийн авлагын талаар 2 албан шаардлага хүргүүлж, 24.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бэлэн мөнгөн касс, харилцах дансны анхан шатны баримтад нийт 59.8 сая төгрөгийн и-баримт хэвлэж хавсаргаагүй байснаас 35.2 сая төгрөгийн и-баримтыг хэвлүүлж хавсаргуулав.
2. Үндсэн хөрөнгийн товчоо болон гүйлгээ балансны компьютер, дагалдах хэрэгсэл дансны 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл 5.5 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав.

3. Тайлант хугацааны засварын зардал болох 10.1 сая төгрөгийн ажил гүйлгээний утгыг хаалтын гүйлгээ гэж бүртгэснийг залруулав.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 170 мэдээлэл байршуулахаас 49 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Мөн тайлант хугацаанд 55 гэрээ байгуулсан, хүний нөөцтэй холбоотой 8 тушаал гаргасан боловч гэрээг баталсан албан тушаалтан, тушаал гаргасан удирдлага ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг шилэн дансанд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв бодитой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. “Монгол кино нэгтгэл” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд нэр бүхий 22 байгууллага, хувь хүнтэй холбоотой 2-15 жилийн хугацаатай 28.2 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар анхан шатны баримтын бүрдэл, авлагын дансыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын бэлэн мөнгөн касс, харилцах дансны 101 ажил гүйлгээний нийт 24.6 сая төгрөгийн баримтын бүрдэл дутуу, и-баримтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтад нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгах.

1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг мөрдөж ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/16/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны тухай хуулийн дагуу 170 мэдээлэл оруулахаас 49 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна. Мөн Шилэн дансны цахим системийн "бусад" хэсгийн 1-д "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл"-ийг (Тухай бүр) байршуулах гэсэн нүдэнд "мэдэгдэл гаргах үйл ажиллагаа явагдаагүй, мэдэгдэл гаргаагүй" гэж хаасан байна.	53.6	Албан шаардлага өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Түвшиндэмбэрэл Г.Төрбат
2	Нэр бүхий 22 байгууллага, хувь хүнээс авах төлөгдөх эсэх нь тодорхойгүй, эрсдэлтэй авлага байна.	28.2	Албан шаардлага өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Түвшиндэмбэрэл Г.Төрбат
3	Бэлэн мөнгөн касс, харилцах дансны 101 ажил гүйлгээний баримтын бүрдэл дутуу, и-баримтгүй байна.	24.6	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Түвшиндэмбэрэл Г.Төрбат
ДҮН		106.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 319/00170069

Улаанбаатар хот

С.ӨГ- 2021/16/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 170 мэдээллээс, 53,618,230 (тавин гурван сая зургаан зуун арван найман мянга хоёр зуун гучин) төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн хүний нөөцтэй холбоотой 8 тушаал гаргасан боловч тушаал гаргасан удирдлага ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв бодитой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн, албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1- заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-ын захирал О.Түвшиндэмбэрэл, ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ДАШДАВАА

Л.ОТГОНБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 320/А0170069

Улаанбаатар хот

СЭТ-2021/6/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд нэр бүхий 22 байгууллага, хувь хүнтэй холбоотой 2-15 жилийн хугацаатай 28,230,690.90 (хорин найман сая хоёр зуун гучин мянга зургаан зуун ерэн) төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-ын захирал О.Түвшиндэмбэрэл, ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ДАШДАВАА

Л.ОТГОНБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264211

\\10.10.10.20\Bichig_Khureg\Alban Shaardlaga\2021\031\Auditin 2-ir Газар\123.Docx

001080430